

11 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Удирдлага, зохион байгуулалтын талаар****Төрийн үйлчилгээний чиглэлээр:**

Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу төсөвт 5 байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд Аймгийн ХШҮ ний ажлын хэсгийн өгсөн зөвлөмжийн дагуу сумын ажлын хэсэг 11 сарын 21,22 төсөвт 5 байгууллага дээр ажиллаж байгууллагуудын дотоод ажил төлөвлөгөө тайлан , байгууллагуудын дарга нарын сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, архив албан хэргийн стандарт тушаал шийдвэрт хяналт шалгалт хийж цахим системд тайлагнах талаар заавар зөвлөмж өгч ажилласан. 11 сард ЕБС, Хүүхдийн цэцэрлэгийн боловсролын үйлчилгээнд нийт 100 иргэнээс санал асуулга авсан. Санал асуулгаар ЕБС –ийн талаар 6 асуудлаар иргэдээс санал хүсэлт ирүүлснийг сумын засаг даргын албан тоотоор хүргүүлж хугацаатай үүрэг өгөөд ажиллаж байна. Хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээнд 100 иргэдээс санал асуулга авахад санал гомдол ирээгүй талархалын үгс ирүүлсэнийг цэцэрлэгийн эрхлэгчид хүргүүлээд байна.

E-Mongolia.mn-ээр

- Нийгмийн даатгалын лавлагаа – 8 хүн
- Жолоочийн үнэмлэх шинээр захиалах – 1 хүн
- Иргэний үнэмлэхний лавлагаа – 12
- Гэрлэлтийн лавлагаа – 1
- Шүүхийн шийдвэрээр бусадад өр төлбөргүй лавлагаа - 1
- Иргэний үнэмлэх шинээр захиалах – 1
- Зээлийн мэдээлэл - 1

Нийт 25 хүн лавлагаа аваад байна

Нотариатын үйлчилгээг 54 хүнд өгөөд байна.

Сумын Засаг даргын ивээл дор Төрийн албан хаагчдын Нөхөрсөг спортын арга хэмжээг 2022 оны 11 сарын 28 нд зохион байгуулагдахаар удирдамжийг батлуулан төсөвт байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах , төрийн албан хаагчдын ажлын ачаалаллыг багасгах зорилгоор шилжин явах цомтойгоор жил бүр уламжлал болгон 4 төрлөөр зохион байгуулагдахаар болсон. Багуудийн ирүүлсэн мэдүүлгээр төсөвт 5 байгууллагын 8 багийн 98 төрийн албан хаагчид оролцохоор бүртгүүлсэн байна. Уг тэмцээний зардалд сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 500,0 мян төгрөгийг гаргаад дэмжиж ажилласан.

Сумын Хүүхдийн 5-р чуулганыг 2022.11.28 нд зохион байгуулсан. Хүүхдийн чуулган “Хөгжилд хүүхдийн оролцоо” уриан дор зохион байгуулагдсан. Чуулганд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, ТГ-ын дарга, багуудын Засаг дарга нар , байгууллагуудын дарга нар урилгаар оролцсон. Нийт сургуулийн 312 хүүхдүүд чуулганд оролцож үгээ илэрхийлж санал бодлоо солилцсон.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Та асуу-Бид хариулья уулзалт ярилцлага арга хэмжээг зохион байгуулсан. Нийт хөгжлийн бэрхшээлтэй 19 иргэд хамрагдсан. Уулзалт ярилцлагад тамгын газрын хууль эрх зүйн мэргэжилтэн, санхүү албаны дарга, халамж, нийгмийн даатгалын мэргэжилтэн, нийгмийн бодлогын мэргэжилтэн, багийн нийгмийн ажилтан нар оролцож мэдээ мэдээлэл хийж санал бодлыг сонссон. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас 300,0 мян төгрөгийг зарцуулж халуун чацаргана, кофе, печень өгч, Дартсын тэмцээн зохион байгуулсан.

ЕБС: Хүүхдийн урлагийн наадам Баруун-Урт суманд 11 сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан. Хүүхдийн урлагийн наадамд сургуулийн дуу хөгжмийн 2 багшийн удирдлага дор 20 сурагч оролцож гоцлол дуу, язгуур урлагийн төрөлд "Хүрэл" медаль хүртлээ. 11 сарын 21-ний өдөр Баруун-Урт суманд зохион байгуулагдсан НОГООН ГЭРЭЛ-ЦАГААН ШУГАМ тэмцээнд сургуулиа төлөөлөн 5-р ангийн 14 сурагч 2 багшийн хамт амжилттай оролцлоо.

Дорнод аймаг Зүүн бүсийн Эко клубуудын "Хүүхэд бидний шийдэл" нэгдсэн уулзалтанд 3 сурагч 1 багшийн хамт амжилттай оролцсон.

Баруун-Урт суманд зохион байгуулагдсан бөхийн барилдаанд 8-9 насны ангилалд 1 сурагч 4 байр эзэлж "УРАН БАРИЛДААНТАЙ БӨХ"-өөр шалгарлаа.

Соёл: Удирдлагаас өгсөн чиг үүргийн дагуу 8 албан бичиг хүлээн авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг чиглэл бүрээр гаргаж тамгын газарт хүргүүлээ. Соёлын бүтээлч сарын хүрээнд зохион байгуулагдах ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Бүтээлч сарын хүрээнд зохион байгуулсагдсан "Бүтээлч ажилтан" шалгаруулах уралдаанд удирдамж чиглэлийн дагуу 5 ажилтны материалыг илгээсэн.

11-р сард Соёлын бүтээлч сарын хүрээнд хийж хэрэгжүүлэх 15 ажлыг төлөвлөн 90%-ийг гүйцэтгэлтэй ажиллаж байна. Соёл урлагийн нэгдсэн 13 арга хэмжээ зохион байгуулагдаж үйл ажиллагаандаа 326 иргэд хүүхдийг оролцуулж 2670 иргэнд соёл, урлагийн боловсрол олгох үйлчилгээг үзүүлсэн байна.

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Номын сангийн танхимын үйлчилгээгээр 211 иргэнд 598 номоор, зөөврөөр 25 иргэнд 39 номоор нийт 236 иргэнд 673 ш номоор үйлчилсэн байна.

.Бүтээлч номын санч шалгаруулах уралдаанд удирдамжийн дагуу судалгаа ном зүйн ажлын нэгтгэлийг хийж ажиллаж байна.

Номын сангийн цахим бүртгэлд нийт номын фондны 70%-ийг шивээд байна.

СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын өвийг өвлөн уламжлагчдыг аймгийн телевизийн бичлэгэнд хамруулж ажилласан. Соёлын бүтээлч сарын хүрээнд Соёлын өвийн цахим танилцуулга шторкыг бэлтгэн цахим орчинд сурталчлан таниулж ажиллалаа.

Сумын ИТХ, ЕБС-тай хамтран Танхимын соёлын аялалыг зохион байгуулан бага ангийн 56 сурагчдыг хамруулан үзүүлэн зургаар ТСДГ-ыг танилцуулан зохион байгуулан ажиллаа.

ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Бүжгийн дугуйлан 45 сурагчтайгаар 11-р сард нийт 6 удаагийн 11 цагийн сургалтыг зохион байгуулан ардын бүжгийн дасгалыг жигдрүүлэн ардын 4 бүжиг, цэнгээнт 2

бүжиг зааж сургаад байна.Хөгжмийн дугуйланд морин хуур 6, лимбэ 2, цахилгаан хөгжим 5, хуучир 2 нийт 15 сурагчид 10 өдрийн 18 цагийн сургалтанд хамрагдлаа.

СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:

Сумын баялаг бүтээгчийн холбоотой хамтран Монгол бахархал нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж өдөрлөг арга хэмжээ баялаг бүтээгчдийн бүтээлийн үзэсгэлэн азын сугалааг зохион байгуулсан.

Ахмадаа сонсоё- Асуудлаа шийдье аяны хүрээнд ахмад уран сайханчдын оролцсон өнөд дуурсагдах аялгуу нэгдсэн тоглолтыг зохион байгуулсан.

Мөн аяны хүрээнд Ахмад нэг өдөр арга хэмжээг 2 удаа зохион байгуулан хамтран ажилласан. Соёлын өв үндэстний дархлаа илтгэлийн уралдааныг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

2022 оны 11 сарын 26-ны байдлаар 33өвчтөн хэвтэн эмчлүүлсэн. Үүний20 насанд хүрэгчид, 13 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн.

Амбулаторийн үзлэг 815, урьдчилан сэргийлэх үзлэг 268байна.

Түргэн тусламжийн дуудлага 64 ирснээс алсын дуудлага–15 , ойрын дуудлага 49 ирсэн байна. Дуудлагыг цаг тухай бүрд нь барагдуулсан.

- ЭМТөвд хэвтэн эмчлүүлэгчдэд “Хавдараас хэрхэн сэргийлэх – эрүүл байх энгийнээс” сургалтын тогтмол хийж байна. Үүнд ЭМТөвд хэвтэн эмчлүүлж буй 421 хүнд сургалт мэдээлэл хийсэн.
- Хөх умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдэд хөхөө өөрөө шалгах аргын талаар болон, умайн хүзүүний эсийн шинжилгээ өгөхийн ач холбогдол зэрэг гарын авлага тараасан.
- Өсвөр насны хөвгүүдийн тулгамдсан асуудал болон тамхины хэрэглээ ба хор хөнөөл сэдвээр сургалт зохион байгуулж, АХА тэмцээнийг зохиосон.
- Үүнд 8-12 ангийн 12 бүлгийн 286 сурагчдад хийсэн. Үүний 47,5% нь хөвгүүд байна.

Мөн жилд 2 удаа зохион байгуулагддаг үзлэг шинжилгээнд 9-12 ангийн 112 хөвгүүн хамрагдсан. Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар мэдээлэл хийж хүүхдүүдийн санал бодлыг сонсож харилцан яриа өрнүүллээ. Үүнд 6-7 ангийн 46 хөвгүүд хамрагдсан.ЕБСургуулийн 1-12 ангийн нийт хүүхдүүдэд эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 700 хүүхэд хамруулснаас 324 нь хөвгүүд байна. Үүнээс:

- Жингийн илүүдэлтэй -6
- Харааны эмгэг -4
- Сонсголын эмгэг -14

Шүдний эмгэг -445 илэрсэн. Төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж байна.

Дөрөв : Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

МЭТ: 2022 оны 11 дүгээр сарын 09-өөс 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Зүүн бүсийн мал эмнэлгийн чухал асуудлууд 2022” бүсийн зөвлөгөөнд мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгжийн 7 эмч, мэргэжилтэн оролцож мал эмнэлгийн тасгийн тулгамдаж байгаа асуудлын талаар тархвар зүйч мэдээлэл бэлтгэн танилцуулсан.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын вакцинжуулалтанд сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/158 тоот захирамжаар 633 өрхийн 35849 толгой үхэр, 11886 толгой тугал, нийт 47735 толгой малыг хамруулж дүн мэдээг нэгтгэн хүргүүлээд байна.

Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/144 тоот захирамжаар сумын хэмжээний 543 өрхийн 247243 толгой хонь, 98715 толгой хурга, нийт 345958 хонийг гоц халдварт хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд хамруулаж дүн мэдээг нэгтгэн хүргүүлээд байна.

2022 оны жилийн эцсийн тоон, бичмэл тайлан, аймгийн Засаг даргын 02, 06, 07 тоот албан даалгаврын биелэлт, 2022 онд мал эмнэлгийн чиглэлээр гарсан захирам, мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан 01 тоот хяналт шалгалтын тайланг гарган мал эмнэлгийн газарт хүргүүлсэн.

Тав : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Тус сумын 5-р багийн нутаг болох Бүрэнцогт уул уурхайн эвдэрсэн газарт 4 гад техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэхээр аймгийн ажлын хэсэг ирж газартайн танилцаж “Хунт-Өгөөж” ХХК, “Говь мастер” ХХК, “Эрээн толгой” ХХК-аар хийлгэсэн.

11-н сарын байдлаар 6-н зээрийн зөвшөөрлийг 6-н иргэн авсан. Зөвшөөрлийн хураамжийн мөнгийг холбогдох дансанд тушаасан.

Зүүн бүсийн “Янзаган хүрээг хайрлаарай” арга хэмжээнд эко клубын 3-н сурагч, багш, байгаль хамгаалагч нар хамрагдсан. Бүсийн уулзалтанд хийсэн ажлын талаарх болон хээрийн аялалд явсан талаар мэдээлэл өгсөн.

Тус сумын 2-р багийн нутаг “Залаагийн булаг”-ийг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 10 сая төгрөгөөр хашсан. Үүнийг ажлын хэсэг сумын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.

